



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар Б/26

Хэрлэн сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2, 1.2.2, 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Агентлаг, байгууллагын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн Орон нутгийн өмчийн газрын дарга Г.Лхагвахатан, Цагдаагийн газрын дарга, хурандаа Д.Батхүү нарт 1, 2 дугаар улирлын мөнгөн урамшуулал олгосугай.

2.Батлагдсан төсөвтөө багтааж, 1, 2 дугаар улирлын мөнгөн урамшууллыг тус бүр албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож олгохыг Орон нутгийн өмчийн газар, Цагдаагийн газрын Нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ